



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 05 сарын 29 өдөр

Дугаар А/118

Бат-Өлзий сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.7, 48.2.9 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хууль бус мод, хуш модны самар бэлтгэхээс урьдчилан сэргийлэх, ойжуулалт, бусад хяналт шалгалтаар ажиллахад албан хаагчдын мотоциклийг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Н.Бат-Эрдэнэ (Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүд: Д.Очирхуяг (Сум дундын Ойг ангийн дарга)

Н.Батсайхан (Татварын улсын байцаагч)


Б.Энхмаа (Байгаль хамгаалагч)

Ц.Маргад-Эрдэнэ (Засаг даргын Тамгын газрын нярав)

2.Захиалагчийн техникийн тодорхойлолтод заасны дагуу хүлээн авч, акт үйлдэн ажлын гүйцэтгэл, үр дүнг тайлагнахыг ажлын хэсэг (Н.Бат-Эрдэнэ)-д даалгасугай.

3.Байгаль хамгаалах, нөхөн сэргээх зардлаас санхүүжүүлсэн Хууль бус мод, хуш модны самар бэлтгэхээс урьдчилан сэргийлэх, ойжуулалт, бусад хяналт шалгалтаар ажиллахад албан хаагчдын мотоциклийг өмчид бүртгэж, ашиглалт, хамгаалалтад байнгын хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Ч.Батдулам), өмч хамгаалах байнгын зөвлөлийн дарга (Э.Дашдулам) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.АМГАЛАН